



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/269

Номгон

Г

Г

Бод малын зохиомол хээлтүүлгийн
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар "Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай" тогтоолын 90 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Бод малын зохиомол хээлтүүлгийн ажлыг 2026 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 10-ны хооронд технологит хугацаанд зохион байгуулсугай.

2.Бод малд зохиомол хээлтүүлэг хийх ажлын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх ажилд шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Тус ажлыг мэргэжил арга зүйгээр удирдаж, чанартай, үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Т.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Энхбаяр)-д даалгасугай.



626010731



Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Нэг үхрийн зардал	Нэг бүрийн үнэ /төг/	Тоо, хэмжээ	Нийт зардал
1	2	3	4	5	6	7
1	Сидр	Ширхэг	49,500	49,500	50	2,475,000
2	Гүн хөлдөөсөн үр	Тун	20,000	10,000	100	1,000,000
3	Шингэн азот	Литр	-	13,200	30	396,000
4	Үрлэгч гуурс	Ширхэг	3,000	1,500	100	150,000
5	Ороо идэвхжүүлэгч	Тун	6,000	6,000	50	300,000
6	Гонадотропин (HCG-XГ)	Тун	6,200	6,200	50	310,000
	Нийт					4,631,000

№	Томилолтын зардал	Хоног	80,000	16	1,280,000
			150,000	6	900,000
2	Хяналтын зардал	Хувь			1,000,000
3	Шатахууны зардал	Литр			2,189,000
Нийт					10,000,000

oOo